

АГУУЛГА

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2. Төслийн хүчин чадал	5
1.2.1. Төслийн барилга байгууламж.....	5
1.3. Төслийн дэд бүтэц.....	9
1.3.1. Цахилгаан хангамж.....	9
1.3.2. Төслийн галийн усан сангийн хэрэглээ, галын систем	9
БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ ...	11
2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил	11
2.2. Физик газарзүйн нөхцөл	11
2.3. Уур амьсгал	13
2.4. Агаарын чанар.....	13
2.5. Физик бохирдол	14
2.6. Хогийн цэг.....	14
2.7. Гадаргын ус	15
2.8. Хөрсөн бүрхэвч.....	16
2.9. Ургамлан нөмрөг	18
2.10. Амьтны аймаг	19
2.11. Тусгай хамгаалалттай газар нутаг	20
2.12. Нийгэм эдийн засаг	21
БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	23
3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл	23
3.2. Агаарт үзүүлэх нөлөөлөл	23
3.3. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл	24
3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл.....	24
3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	24
3.6. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь.....	24
БҮЛЭГ-4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ	25
БҮЛЭГ-5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	30
5.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	31
5.3. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	32
5.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	32
5.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	33
5.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	33
5.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	34
5.8. Бомт-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол	4
Хүснэгт 3. Хөргөлтийн усны хэмжээ	9
Хүснэгт 4. Гал унтраах хөөсөнд ашиглах усны хэмжээ	10
Хүснэгт 5. Агаарын чанарын хэмжилтийн дүн.....	13
Хүснэгт 6. Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн дуу шуугианы хэмжилт	14
Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ.....	16
Хүснэгт 8. Хөрсний дээж авсан цэгийн солбицол	17
Хүснэгт 9. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд	18
Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн	18
Хүснэгт 11. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж	18
Хүснэгт 12. Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо /хороогоор/	22
Хүснэгт 13. Сонгинохайрхан дүүргийн өрхийн тоо.....	22
Хүснэгт 14. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс	23
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын нэгдсэн дүн	29
Хүснэгт 16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.....	30
Хүснэгт 17. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	31
Хүснэгт 18. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	32
Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	33
Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	33
Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	34
Хүснэгт 22. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	35

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг /Google earth/.....	5
Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал.....	7
Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг.....	11
Зураг 4. Төслийн талбайн бүс бүслүүрийн зураг	12
Зураг 5. Төслийн талбайн физик газарзүйн мужлалын зураг	12
Зураг 6. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал.....	14
Зураг 7. Төслийн талбай орчмын усны сав газар	15
Зураг 8. Гүний Гүний худгийн усны унд ахуйн шинжилгээний дүн	15
Зураг 9. Гүний худгийн харагдах байдал.....	16
Зураг 10. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг	17
Зураг 11. Төслийн талбайн гадаргын төрх байдал	17
Зураг 12. Хөрсний зүсэлт	18
Зураг 13. Төсөл хэрэгжих талбайн ургамалжилтын зураг	19

Зураг 14. Төсөл хэрэгжих талбай орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	20
Зураг 15. Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	21
Зураг 16. Санал болгож буй хогийн савны жишээ зураг	27
Зураг 17. Мониторинг хийх, дээж авах цэгийн байршил.....	36

БҮЛЭГ-1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Эко вест ойл” ХХК нь 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/206 тоот захирамжийн дагуу 13301 м² газарт “Газрын тосны агуулах” зориулалттай 000026204 тоот газар эзэмших гэрчилгээг 15 жилийн хугацаатай авсан байна. Мөн 2020 оны 10-р сарын 21-ний өдрийн А/469 тоот захирамжийн дагуу 787 м² газарт “Төмөр зам бүхий далан” зориулалттай 000017992 тоот газар эзэмших гэрчилгээг 15 жилийн хугацаатай авсан байна.

Төслийн талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутагт хамаарах бөгөөд Улаанбаатар хотоос 45 км -ийн зайд Рашаант өртөө буюу 361-р гарамын ойролцоо байрлана.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар
1	“Эко вест ойл” ХХК	5956145	9011542093

“Эко Вест Ойл” ХХК /5956145/-нь 2015 онд гадаад худалдааны чиглэлээр үүсгэн байгуулагдаад 6 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа ба энэ хугацаанд ОХУ-с чанар стандартын шаардлага хангасан”газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлж байна.

Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол

1801919333 нэгж талбарын дугаартай төслийн талбай			
Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Талбайн хэмжээ, м ²
1	48° 3' 42.772"	106° 33' 51.674"	13301
2	48° 3' 42.772"	106° 33' 51.674"	
3	48° 3' 46.742"	106° 33' 51.223"	
4	48° 3' 46.717"	106° 33' 50.857"	
5	48° 3' 46.717"	106° 33' 50.856"	
6	48° 3' 47.569"	106° 33' 50.622"	
7	48° 3' 48.597"	106° 33' 50.966"	
8	48° 3' 47.943"	106° 33' 56.826"	
9	48° 3' 42.827"	106° 33' 53.065"	
1801919332 нэгж талбарын дугаартай төслийн талбай			
1	48° 3' 46.717"	106° 33' 50.856"	787
2	48° 3' 46.717"	106° 33' 50.857"	
3	48° 3' 46.742"	106° 33' 51.223"	
4	48° 3' 42.772"	106° 33' 51.674"	
5	48° 3' 42.772"	106° 33' 51.674"	
6	48° 3' 42.761"	106° 33' 51.378"	
7	48° 3' 44.514"	106° 33' 51.183"	
8	48° 3' 45.656"	106° 33' 51.030"	
9	48° 3' 46.717"	106° 33' 50.856"	

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг /Google earth/



1.2. Төслийн хүчин чадал

Тус талбайд 2019 онд үйл ажиллагаагаа өргөжүүлж бүрэн урт нь 571 метр, Р-50 Р-43 маркийн зам төмөртэй, Р-43 маркийн салаалах сум, ачилт буулгалтын фронт 110 метр, нэгэн зэрэг 8 ширхэг вагон буулгах хүчин чадал бүхий салбар төмөр замыг өөрсдийн хөрөнгөөр бүтээн байгуулсан юм. Зам тээврийн яам болон УБТЗ ХНН-ын холбогдох бүх бичиг баримт зөвшөөрлийг авсан бөгөөд улсын комисс ажиллаж салбар төмөр замыг хүлээн авч гэрчилгээгээ хүлээнгэн өгсөн. Газар дээр газрын тосны бүтээгдэхүүн хадгалах 50м³ багтаамжтай 15 ширхэг сав нийт 750м³ тоноглолуудын хамт 30 ширхэг савны суурь шатахуун ачих автостакад 2 ширхэг зам талбай тавцан шат нэгэн зэрэг 4 ширхэг цистерн буулгах шугам хоолой 2 ширхэг илүүдлийн сав 4 ширхэг аянга зайлуулагч 2 ширхэг ачих буулгах насос 10 ширхэг талбайн гэрэлтүүлэг 8х10 хэмжээтэй 6 өрөө 80м² ажлын байр гүний худаг цэвэр бохирын холболтыг шийдсэн байрны гадна 6 ширхэг машины зогсоол 380ВТ-ын цахилгаан шугам 9 ширхэг хяналтын камер 1.33 га газар бүрэн бетонон хашаа зэрэг бүтээн байгуулалт хийгээд байгаа юм.

1.2.1. Төслийн барилга байгууламж

Вагонцистернээс буулгах байгууламж: Тус байгууламжид тус бүр нь 60-70 тн багтаамжтай вагонцистернээс 8 байраар газрын тосны бүтээгдэхүүнийг нэгэн зэрэг буулгах боломжтой бөгөөд шатахууны төрөлд зориулан 2 коллектор төлөвлөсөн болно. Вагонцистерны хүйсээр шатахуун буулгах боломжгүй тохиолдолд вагонцистерны дээд люкээр холболт хийж, төмөр замын эстакадын дэргэд төлөвлөсөн насосоор шатахууныг 1 байраар буулгах боломжтой юм.

Вагонцистернд ачих байгууламж: Газрын тосны бүтээгдэхүүнийг вагонцистернд 8 байраар нэгэн зэрэг хүйсээр ачих боломжтой ба шатахууны төрөлд зориулсан 2 коллектортой болно.

Насос станц: Төлөвлөж байгаа насос станцад газрын тосны бүтээгдэхүүнийг вагонцистернээс хүлээн авах, вагонцистернд ачихад зориулсан 120-160 м³/цаг зарцуулгатай 3 ширхэг насос төлөвлөсөн ба насос тус бүр шүүр, манометр, үл буцаах клапантай байна. Шугам хоолой тус бүрийг шатахууны төрлөөр ялган суллах зориулалттай шугам хоолой, суллах савыг төлөвлөсөн болно.

Шатахуун хадгалах савны парк: 90 -ээс доош болон дээш октантай автобензин, дизелийн түлш хадгалах зориулалтаар 2000м³ багтаамжтай 3 ширхэг босоо цилиндр ган савыг бариад байна.

Савны дотор талыг зэврэлтээс хамгаалах бүрхүүлээр будна.

Гадна хийцийг зэврэлтээс хамгаалах, химийн бүтээгдэхүүнд болон элсэн шуурга, халуун хүйтний эрс тэс цаг уурт тэсвэртэй, нарны гэрлийг цайвар өнгийн бүрхүүл- будгаар будна.

Ослын үед асгарсан шатахууныг тархахаас хамгаалах зорилгоор савнуудын эргэн тойрон бетон далан байгуулна. Сав парк доторх талбайг бетоноор хучна. Ослын байдлаар асгарсан шатахууныг тархаахгүй байх зорилгоор ослын шугам дээр тусгай зориулалтын хаалт төлөвлөв. Шугам хоолойн шатахууныг суллах 10м³ багтаамжтай 2ш, автоачих эстакадын талбайд ослын байдлаар асгарсан шатахууныг цуглуулах зориулалтын 25м³ багтаамжтай 1ш хэвтээ савуудыг тус тус газар доор суурилуулахаар төлөвлөсөн.

Амьсгалах хоолой: Суллах саванд амьсгалах хоолой болон хэрэгсэл төлөвлөв. Тус төсөлд -40 хэмийн хүйтний улирал, салхи, халуунд тэсвэртэй, Европын 94/9/ЕС журмын дагуу тэсрэлтийн орчинд ашиглахад зөвшөөрөгдсөн SIRA 06ATEX9193X сертификаттай, даралт болон вакуумын клапангууд эсвэл үүнтэй дүүцэх техникийн үзүүлэлттэй клапангуудыг үйлдвэрт өндөр нарийвчлалаар тохируулагдсан, сайн чанарын гуулиар хийсэн амьсгалах хэрэгсэл (клапан)-ийг төлөвлөв.

Автоцистернд ачих төхөөрөмж: Шатахууныг автоцистернд ачих 8 байр төлөвлөсөн ба төрөл тус бүрд дээгүүр ачих зориулалттай ачих гар, шүүр, шингэний тоолуур, автомат клапанг төлөвлөв.

Технологийн хоолой. Технологийн хоолойд газрын тосны бүтээгдэхүүнд зориулсан ASTM A333 стандартад нийцсэн ган хоолой, стандартад нийцсэн фланц, холбох хэрэгсэл ашиглана. Технологийн хоолойн угсаралтын үеийн холболтын гагнаасын бөх батын чанарын үзүүлэлт нь ган хоолойн үзүүлэлтээс бага байж болохгүй.

Сав болон шатахууны шугам хоолойн бүх хаалт, хэрэгсэл нь газрын тосны бүтээгдэхүүнд зориулсан, ASTM 352, 350, API 600, 598 стандартууд, үүнтэй дүүцэх бусад олон улсын стандартад нийцсэн байна. Шугам хоолойн угсаралтын явцад гагнуурын чанарт үзлэг, үл эвдэх аргын шалгалт хийж шугам хоолойг угсарч дууссаны дараа даралтаар туршилт хийнэ. Туршилтад ажлын даралтыг 1.25 дахин буюу 0.9 МПа даралтыг 5 минутын туршид өгч шалгах ба дараа нь ажлын даралтын хэмжээнд бууруулан шалгалтыг үргэлжлүүлнэ. Технологийн хоолойг зэврэлтээс хамгаалах, химийн бүтээгдэхүүнд болон элсэн шуурга, халуун хүйтний эрс тэс цаг уурт тэсвэртэй, нарны гэрлийг ойлгох цайвар өнгийн бүрхүүл-будгаар будна.

Гадна агаарын температурын өөрчлөлтөөс шугам хоолойд үүсэх илүүдэл даралтыг зайлуулах зорилгоор босоо савны орлого-зарлагын хоолой дээр даралтын хамгаалах клапанг төлөвлөсөн болно. Уг клапанг шатахууны төрөл тус бүрийн шугам хоолойд угсрах хэрэгтэй.

Ослын систем: Автоцистернээс буулгах болон ачих талбайд ослын байдалтай асгарсан шатахууныг тусгай суваг, хоолойгоор дамжуулан ослын саванд юүлэн авах.

Гал унтраах систем: Босоо савны хөргөлтийн болон хөөсний уусмалын усны хэрэгцээг галын суурин автомат бус систем төлөвлөхөөр шийдэж, гүний худгаас ус татах боломжтой.

Конторын барилга: Барилгын хэмжээ 10.0х8.0м ба операторын өрөө, хурлын өрөө, дулааны үзель, конторын өрөө, ажилчдын цайны газар, ариун цэврийн өрөө, ажилчдын хувцас солих өрөө, цахилгаан шитний өрөө, сервэрийн өрөө, лабаратори, дээж авах өрөө зэрийг төлөвлөсөн байна.

Зураг 2. Төслийн талбайн харагдах байдал







1.3. Төслийн дэд бүтэц

1.3.1. ЦАХИЛГААН ХАНГАМЖ

“Эко вест ойл” ХХК-ийн 2019 оны 01-р сарын 14-ний өдрийн албан хүсэлтийн дагуу Эрчим хүч хариуцсан албаны 2019 оны 01-р сарын 31-ны өдрийн техникийн нөхцөлийн дүгнэлт, цахилгаан тодруулгаар 50кВт, 0.38кВт-ын хүчин чадалтай, III зэрэглэлийн дэд станцыг Партизан 35/10кВ дэд станцын ячейк №6-аас гарсан агаарын шугамын тулгуур №128-аас кабель шугамаар холболт авч, шугамын төгсгөлд КТПН-160/10/0.4кВ хүчин чадал бүхий станцыг суурилуулсан байна.

1.3.2. Төслийн ГАЛИЙН УСАН САНГИЙН ХЭРЭГЛЭЭ, ГАЛЫН СИСТЕМ

Барилга барилга угсралтын “Эко вест ойл” ХХК нь галын усан сангийн зургийг ерөнхий төлөвлөгөөний өндөржилт, захиалагч байгууллагын зургийн даалгавар зэргийг үндэслэн хур тунадас их хэмжээтэй орсон үед бороо усыг зайлуулах, талбайд асгарсан нефтийн бүтээгдэхүүнийг зайлуулах зорилгоор талбайн ус цуглуулах систем төлөвлөн, полиэтилен шүүрт худагт хатуу хог хаягдал, чулуу шороог тунахаар байхаар угсарч, тунасан хог шороог гараар цэвэрлэх юм.

Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын “Галын аюулгүйн нормд”-д зааснаар ГТБА нь эхний ээлжийн хүчин чадлаар ажиллахад IIIб зэрэглэлийн агуулахын хэмжээнд үйл ажиллагаа явуулах тул хөөсөөр унтраах болон усаар хөргөх системд нормын 8.3, 8.6, 8.8-р заалтын дагуу галын хөдөлгөөнт техник хэрэгсэл ашиглахаар төлөвлөж, галын усыг агуулахын эдэлбэр газарт байрлах 600 м³ -ын багтаамжтай 1 ширхэг усан сангаас хангах бөгөөд усан санд усны сэлбэлт хийх зориулалттай 2021 онд гаргасан 55 м-ийн гүн, 2.0 л/с-ын ундрагатай гүний худгаас хангах юм.

Усны хэрэгцээний тооцоо :

Хүснэгт 3. Хөргөлтийн усны хэмжээ

Гал унтраах арга хэрэгсэл	Хөргөх хугацаа (цаг)	Эрчим (л/сек)			1 цагийн хэрэглээ (м³)	Нийт хэрэглээ (м³)	Үүнээс хангах эх үүсвэр	
		Шатаж байгаа	Зэргэлдээ сав	Бүгд			Гүний худгаас (м³)	Усан сангаас (м³)
Галын хөдөлгөөнт хэрэгсэл ашиглахаар төлөвлөсөн бол	6	38.13	14.3	52.4	188.8	1133	21.6	1111

Хүснэгт 4. Гал унтраах хөөсөнд ашиглах усны хэмжээ

Гал унтраах арга хэрэгсэл	Гал унтраах хугацаа (мин)	Шахах эрчим (л/м ² сек)	Савны талбай (м ²)	Нийт хэрэглээ (м ³)
Дунд өсөлттэй хөөсийг ашиглан гал унтраах	15	0.05	180.9	8.1

Нийт хөргөлтийн болон хөөсний уусмалын усны хэрэгцээг галын суурин автомат бус систем төлөвлөхөөр шийдэж, гүний худгаас ус татах боломжтой тул 500 м³ –ийн усан санг төлөвлөсөн.

Лаг болон ууршуулах талбай

Ууршуулах талбайн 12*15 м², лагийн талбайн 10*10 м² хэмжээтэй байна. Хаягдлыг ууршуулах хэсэг нь эргэн тойронд нь хаалт, хашлага бүхий зориулалтын ууршуулах байгууламжийг хаягдал бодисыг урсгахгүйн тулд газар ухаж суурилуулах ба бодисын овор, хаягдлын төрлөөс хамааран 1.5-2 метр ба түүнээс цааш гүнтэй ухаж, хамгаалах хаалт, далантай зориулалтын техник хэрэгсэл бүхий байгууламж. Бороо, хур орсны дараа болон савны эргэн тойронд хуралдсан усыг ууршуулах талбай руу тусгай шугамаар дамжуулан оруулах хоолойтой, нефть бүтээгдэхүүн асгарсан тохиолдолд шууд ууршуулах талбай руу орно. Босоо савыг жилд нэг удаа цэвэрлэх бөгөөд лагаа бөөгнүүлэн тусгай талбайд шатааж устгал хийнэ. Нефтийн бүтээгдэхүүний лагийг шатаах процесс нь Стокольмын конвенцийн Хавсралт В-д багтсан химийн бодис болон хүрээлэн байгаа орчныг бохирдуулагч бусад олон тооны дутуу шаталтын бүтээгдэхүүн үүсгэдэг экологийн хувьд таагүй процесс юм. Тус компани нь Стокольмын конвенцийн Хавсралт В-гийн, зүйл 5-ын А хэсгийн дэд заалт (f) – ын дагуу энэ аргаас бүрэн татгалзах зорилго тавьж ажиллаж байна.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллөөс хамгаалахын тулд дараах арга механизмуудыг авч ажиллаж байна. Үүнд:

Байгууламжаас шүүрэлт илрүүлэх цооногуудыг холбогдох байгууллагын зааврын дагуу байгуулж, жил бүр хяналт, шинжилгээг хийж гүйцэтгэдэг.

Лаг болон ууршуулах талбайн тогтворжилт аюулгүй байдлыг байнга хянадаг.

Далангийн хаягдлын түвшингээс дээш гарсан өндрийг тогтоосон хэмжээнд байгаа эсэхийг тогтмол шалгаху

Хүн, мал, зэрлэг ан амьтан орохоос сэргийлсэн хамгаалалтын хашаа барьсан.


Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон усыг ил задгай, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээр хаядаггүй.

БҮЛЭГ-2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1. Төсөл хэрэгжих талбайн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт, 13301 м² болон 787 м² талбайг хамран байрлаж байна.

Зураг 3. Төслийн талбайн байршлын зураг




2.2. ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ


Улаанбаатар хот, түүний орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг мужийн баруун урд үзүүрт Туул голын хөндийн 2.5-4 км хүртэл өргөссөн татам олон дэнж, Их Хэнтийн нурууны баруун өмнөд салбар уулс, түүний дэд мужийн ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м үнэмлэхүй өндөртэй Горхи, Тэрэлж, Богдхан, Сонгино Хайрхан Чингэлтэй, Баянзүрх зэрэг биеэ даасан өндөрлөг уулс, тэдгээрийн салбар уулсаар Туул голын 1250-1345 м үнэмлэхүй өндөр бүхий тэвш маягийн хөндийн 2.5-4.0 км хүртэл өргөссөн татам, дээрх уулсын энгэр, бэл, хормой, дэнжид тархан оршдог.

Төсөл хэрэгжиж буй талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужид, Газарзүйн бүсчлэлээр ойт хээрийн бүсэд тус тус багтаж байна.

Зураг 4. Төслийн талбайн бүс бүслүүрийн зураг



Зураг 5. Төслийн талбайн физик газарзүйн мужлалын зураг



2.3. УУР АМЬСГАЛ

Улаанбаатар хот нь хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр зунтай, эх газрын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт хамаарна. Дэлхийн улс орнуудын нийслэлүүдээс хамгийн хүйтэн нийслэлд тооцогддог. Жилд дунджаар 2800 цаг нартай байдаг бол 12-14 өдөр л наргүй өдөр тохиож байдаг байна.

Жилийн дундаж агаарын температур -1.7°C , орон зайн тархалтаар авч үзвэл нутгийн хойд хэсгээр $-4\ldots-2^{\circ}\text{C}$, дунд хэсгээр -2°C -ын орчим, өмнөд хэсгээр $-2\ldots 0^{\circ}\text{C}$ дулаан байдаг.

Уулын байрлал хотгор гүдгэрийн онцлог байрлалаас болоод газрын гадаргын орчимын салхины горим ихээхэн өөр өөр байдаг. Салхины жилийн дундаж хурд 2.6-3.0 м/сек, дундаж их хурд 5 сард 3.4-4.5 м/сек дундажтай байна.

Агаарын чийгшлийн горим нилээд өвөрмөц, агаарын чийгшил нь халуун хүйтэндээ урвуу хамааралтай байдаг. Жилийн дундаж агаарын харьцангуй чийгшил 60 % байдаг. Анхны цас 9 сарын 10 орчимд орж, сүүлчийн цас 5 сарын 20 орчимд ажиглагдана.

Хур тунадасны улирлын хуваарилалт нь муссоны шинжтэй. Олон жилийн дунджаар 203 мм хур тунадас унадаг. Орон зайн тархалтаар авч үзвэл нутгийн хойд хэсгээр 250-350 мм, төв хэсгээр Улаанбаатар, Буянт-Ухаа орчмоор 250-300 мм, бусад нутгаар 150-200 мм хур тунадас унадаг байна. Сүүлийн 5 жилийн хугацааны дунджаас үзэхэд 312 мм бөгөөд 80% нь дулааны улиралд буюу 5-9 дүгээр саруудад ордог. Хамгийн хүйтэн сар болох 12..1-р сарууд бөгөөд агаарын температурын үнэмлэхүй бага утгууд $-39.8\ldots-37.3^{\circ}\text{C}$, хамгийн дулаан сарууд нь 7...8-р сарууд бөгөөд агаарын үнэмлэхүй их утгууд $31.5\ldots 33^{\circ}\text{C}$, Агаарын жилийн дундаж температур -0.9°C /Буянт-Ухаа/, 0.6°C /Амгалан/, 1.2°C /Улаанбаатар/ байдаг.

Улаанбаатар хот орчмоор агаарын харьцангуй чийгийн жил, улиралын хандлагыг авч үзвэл: Хамгийн их утгууд нь намар, өвлийн саруудад ажиглагдаж байгаа нь ХанХэнтийн уулсын нутгаар хүйтний улиралд харьцангуй тогтуун агаарын масс тогтдогтой холбоотой юм. Харин хавар, зуны улиралуудад харьцангуй чийгшлийн бага утгууд ажиглагддаг бөгөөд хамгийн бага утга хаврын /шилжилтийн улиралд ажиглагдаж байна.

2.4. АГААРЫН ЧАНАР

“Эко вест ойл” ХХК –ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутагт байрлах “Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах” төслийн талбайд агаар дахь тоосжилт, агаарын чанарын индекс болон дуу чимээний түвшинг зөөврийн багажуудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ. Дээрх хэмжилт судалгаанд агаарын тоосжилт, чанарыг хэмжигч Temtop LKC-1000 series болон дуу чимээг MS6300 Environment multimeter багажуудыг ашигласан болно.

Хүснэгт 5. Агаарын чанарын хэмжилтийн дүн

№	Байршил	AQI	PM 2.5 ($\mu\text{g}/\text{m}^3$)	PM10 ($\mu\text{g}/\text{m}^3$)	HCHO (mg/m^3)	TVQC (mg/m^3)	Дуу чимээ (dB)	Байршил
1	1 -р цэг 48°03'48.0"N 106°33'56.0"E	14	3.1	4.3	0.01	0.01	36.8	Төслийн талбайд
2	1 -р цэг 48° 3'46.07"N 106°33'51.73"E	9	2.2	3.6	0.01	0.06	37.1	

Төслийн талбайд хийсэн хэмжилтийн дүнгээр Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 17 -ны өдрийн А-327 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад

заасан Агаарын чанарын индексийн дүн, агаарын чанарын ангилалаар цэвэр, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд байна.

Төслийн талбайн орчимд хийж гүйцэтгэсэн тоосжилтын хэмжилт: Агаарын тоосжилтын хэмжилтийн явцад PM10 3.6-4.3 мг/м³, PM2.5 2.2-3.1 мг/м³ утгатай гарч байв. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016-д PM10-100 мкг/м³, PM2.5-50 мкг/м³ байна гэж заасан бөгөөд эдгээр утгаас бага гарч байв. Энэхүү утга нь тухайн үеийн нэг хэмжилтийн утга болно.

Зураг 6. Агаарын чанар, тоосжилт, дуу шуугианы хэмжилт хийж буй байдал



2.5. Физик БОХИРДОЛ

Шуугиан ба доргио нь хүрээлэн буй орчинд хэлбэлзэх долгион хэлбэрээр тархаж, хүн, амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шуугиан ба доргионы тархалтын зүй тогтол нь ижил, байгаль орчин (хүн, амьтан, ургамал, хот, барилга байгууламж)-д үзүүлэх сөрөг нөлөө нь төстэй юм.

Механик системийн тодорхой давтамж бүхий хэлбэлзэх хөдөлгөөнийг доргио буюу чичиргээ гэж нэрлэдэг. Доргио нь газрын хөрс, шал, барилгын эд ангиудаар дамжин хүн, амьтан, ургамал, барилга байгууламж, хөшөө дурсгал зэрэгт нөлөөлөх бөгөөд ихэнх тохиолдолд шуугианы эх үүсвэр болдог.

Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн дуу шуугианы хэмжилт: Хээрийн судалгааны үеэр хэмжилт хийсэн 1 цэгийн дуу шуугианы хамгийн их түвшин 37.1 дБ(А) байсан бөгөөд MNS4585:2016, дуу чимээний сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй үзүүлэлттэй байна. Энэхүү дуу шуугианы хамгийн их утга нь машин явах үед хэмжигдсэн үзүүлэлт юм. Иймд хээрийн судалгаагаар хийгдсэн хэмжилтийн дүн мэдээ нь төслийн талбай орчмын дуу чимээний өнөөгийн түвшинг бүрэн илэрхийлнэ гэж үзэж болно.

Хүснэгт 6. Төслийн талбайд хийж гүйцэтгэсэн дуу шуугианы хэмжилт

№	Байршил	Дуу чимээ (dB)	Байршил
1	1 -р цэг 48°03'48.0"N 106°33'56.0"E	37.1	Төслийн талбайд

2.6. Хогийн цэг

“Эко вест ойл” ХХК-ийн “ГТБА” төслийн талбайд ил задгай овоорсон хур хог байхгүй байна.

Төслийн ажилчдын ахуйн хэрэглээнээс шил, лааз, хуванцар сав, гялгар уут, хоол, хүнсний хатуу хог хаягдал зэрэг үүснэ. Төсөл хэрэгжүүлэгч нь ахуйн гаралтай хог хаягдлыг


“Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог хаядлыг ачиж тээвэрлэх гэрээ” байгуулан зайлуулж байна.

Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь төслөөс үүсэх энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж дээрх гэрээний дагуу үргэлжлүүлэн зайлуулах, аюултай хог хаягдлыг тусгай зориулалтын сав, байранд түр хуримтлуулж “Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан ААН-тэй байгуулсан гэрээний дагуу зайлуулж байх зөвлөмжийг өгч байна.

2.7. ГАДАРГЫН УС

Төслийн талбай нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 тоот тушаалаар баталсан Монгол орны 29 усны сав газраас Хараа голын усны сав газарт хамаарагдаж байна.

Зураг 7. Төслийн талбай орчмын усны сав газар



Төсөл хэрэгжүүлэгч нь унд ахуйн усаа өөрийн талбай дээрх гүний худгаас авч ашиглаж байна. Талбай дээрх гүний худгийн шинжилгээний дүнг нэгтгэвэл химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” стандартын шаардлага хангаж байна. (Шинжилгээний дүнг хавсаргав.)

Зураг 8. Гүний Гүний худгийн усны унд ахуйн шинжилгээний дүн

Анион	1 дм ³			Катион	1 дм ³		
	Мг	Мг-экв	Мг-экв/ %		Мг	Мг-экв	Мг-экв/ %
Cl ⁻	18.8	0.53	8.9	Na ⁺ + K ⁺	32.3	1.40	23.7
SO ₄ ⁻	45.0	0.94	15.8	Ca ⁺⁺	54.1	2.70	45.5

Анион	1 дм ³			Катион	1 дм ³		
	Мг	Мг-экв	Мг-экв/ %		Мг	Мг-экв	Мг-экв/ %
NO ₂ ⁻	0.0	0.00	0.0	Mg ⁺⁺	22.1	1.82	30.7
NO ₃ ⁻	10.0	0.16	2.7	NH ₄ ⁺	0.1	0.01	0.1
CO ₃ ⁻	0.0	0.00	0.0	Fe ⁺⁺	0.0	0.00	0.0
HCO ₃ ⁻	262.3	4.30	72.5	Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.0
Дүн	336.1	5.93	100.0	Дүн	108.6	5.93	100.0

Анион катионуудын нийлбэр: **447.7мг/дм³**

HCO₃⁻–ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: **313.6 мг/дм³**

Физик үзүүлэлтүүд

Өнгө: 0-өнгөгүй,

Үнэр: 0-үнэргүй

Тунадас: 4.07 NTU

Тунгалаг: **30см**

Ерөнхий хатуулаг: **4.52 мг-экв/дм³**

Урвалын орчин: pH-7.80

Цахилгаан дамжуулах чадвар: EC- 502ds/m, TDS:301 ppm

Зураг 9. Гүний худгийн харагдах байдал



2.8. ХӨРСӨН БҮРХЭВЧ


Тус төслийн талбайн хөрс нь Монгол орны Хөрс-Газарзүйн мужлалаар Төв Азийн их мужийн өндрийн бүсшлийн Хангай-Хэнтийн дэд мужийн өмнөдийн 52-аар тойрогт хамаарагдана. Энэ тойргийн уулс, ой бүхий газраар уулын хар шороон, хар хүрэн, тал хөндий, нам хотос хэсгээр хар шороон, хар хүрэн хөрс, голын хөндийн хэсгээр аллювийн нугын хөрс голлон тархана.

Төслийн талбайд элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хархүрэн хөрс тархсан байна. Судалгааны явцад 1 цэгт хөрсний дээж авч хөрсний агрохими болон хүнд металлын агууламжийг тодорхойлуулав.

Хүснэгт 7. Хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн ангилал, талбайн хэмжээ

№	Хөрсний нэр	Талбайн хэмжээ /га/	Эзлэх хувь
1	Хархүрэн хөрс	1.40	100.0
	Нийт	1.40	100.0

Зураг 10. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинжийн зураг



Зураг 11. Төслийн талбайн гадаргын төрх байдал



Хөрсний хүнд металлын бохирдол болон хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг “Green lab” ХХК-ийн хөрсний лабораторит хийлгэв. Судалгааны явцад 1 цэгт хөрсний дээж авч, морфологи бичиглэл хийсэн бөгөөд хөрсний агрохими болон хөрсний хүнд металлын бохирдолыг тодорхойлуулав.

Хүснэгт 8. Хөрсний дээж авсан цэгийн солбицол

Дээж авсан цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг
Дээж 1	48° 03' 45.98"	106° 33' 51.65"

Хархүрэн хөрс А (0-15 см): Хар бараан өнгөтэй, ургамлын үндэс их, үйрмэг чулуугүй, нягтавттар нийцтэй, элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Зураг 12. Хөрсний зүсэлт



Хүснэгт 9. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, d sm	Ялзмаг %	CaCO ₂ , %	Солилцох суурь, мг-экв/100гр			Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	0-20	8.50	0.11	0.213	1.63	1.82	23.2	18.4	4.8	1.5	30

Хүснэгт 10. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	0-20	19.6	41.4	21.8	6.1	9.0	2.2	17.3

Хүснэгт 11. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr /Хром/	Pb /Хар тугалга/	Cd /Кадми/	Zn /Цайр/	Cu /Зэс/	Ni /Никель/
1	0-20	19.8	41.5	-	88.1	36.7	31.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

Хөрсний өнгөн хэсэгт зарим хүнд металлуудын агууламжийг /MNS ISO 11466:2007/атом шингээлтийн спектрометрээр шинжилж MNS 5850:2019 стандарттай харьцуулахад хөрсний дээжинд хар тугалга 20.4 мг/кг, цайр 70.2 мг/кг, зэс 32.3 мг/кг, хром 39.7 мг/кг, никель 28.9 мг/кг, кадми илэрсэнгүй.

Элсэнцэр болон хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хөрсөн дэх хүнд металлын элементийг тодорхойлоход кадми илрээгүй, никель, цайр, зэс, хром, хар тугалга гэх мэт хүнд металлын агууламж MNS 5850:2019 стандарт хэмжээнээс бага гарсан учир хөрс бохирдолгүй байна.


2.9. УРГАМЛАН НӨМРӨГ

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн мужийн Хэнтийн уулын тайгын тойрогт хамрагдана. Ойн дээд хил гол

нуруудад далайн төвшнөөс дээш 2200 м-т орших ба түүнээс дээш төгрөг навчит Хус, Сибирь болон Хонин Арц, Алтай Тэрэлж, тагийн хүйтсүү алаг өвс, Зожих өвст бүлгэмдлүүд алаг цоог тархсан байна.

Төслийн талбайн хүрээнд өмнө нь жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст ургамлын бүлгэмдэлтэй байсан. Одоогийн байдлаар төслийн талбайн эргэн тойронд суурьшлын бүс үүссэн, талбайг бүрэн цементэлсэн ургамлан нөмрөг устсан байдалтай байна.

Зураг 13. Төсөл хэрэгжих талбайн ургамалжилтын зураг



2.10. Амьтны аймаг

Төсөл хэрэгжиж буй нутаг нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол дагуурын тойрогт хамаарна.

Энэ бүс нутагт олон салаа гүн нүх малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллодог мэрэгчид зонхилно. Тэдгээрийн тоонд өвөл ичдэг тарвага, жилийн турш идэвхтэй, хөдөлгөөнтэй байдаг жижиг амьтад орно. Зарим зүйлийн мэрэгчид хэт олширсноос болж хөрс, ургамалд сөрөг нөлөө үзүүлдэг. Шувуудын хувьд өвөл цас багатай, нарлаг өдөр олон учраас зөвхөн нутгийн суурин шувууд төдийгүй умард тундрын шувууд ч өвөлжих аятай нөхцөл бүрддэг байна. Хүнд ойр оршдог шувууд ч олон бий. Энэ бүлэгт хэрээ, улаан хошуут, хадны тагтаа, сохор элээ, үхэр цахлай зэрэг орно.

Эх газрын гандуу уур амьсгалын нөлөөгөөр хуурайсаг болон нуугдамхай хэлбэрийн шавьж, ялангуяа авгалдайн шатандаа далд газар амьдралтай шавьж элбэг байдаг байна.


ХАА-н хортон шавьж нилээд бий бөгөөд тэдгээрийн дотроос шумуул, дэлэнч, хөх түрүү зэрэг цус сорогчид МАА-д хохирол учруулсаар байна.

Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахын орчмын газар нь суурьшлын бүс учир түүний нөлөөгөөр ан амьтад үргэж дайжсан. Цөөн тохиолдолд жижиг мэрэгч амьтад тааралдана.

2.11. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

Төсөл хэрэгжих газар нутагтай хамгийн ойр оршиж буй тусгай хамгаалалттай газар нутаг нь Чингэлтэй хайрхан уулын 1, 2-р хэсэг бөгөөд төслийн талбайгаас зүүн хойд зүгт 14.1 болон 17.7 км зайтай оршиж байна. Мөн төслийн талбайн зүүн урд хэсэгт Богдхан уулын дархан цаазат газар байрлаж байна.

Зураг 14. Төсөл хэрэгжих талбай орчмын Улсын тусгай хамгаалалттай газар нутаг



Горхи Тэрэлж – Байгалийн цогцолборт газар: Засаг захиргааны хувьд УБ хотын Налайх дүүрэг, Төв аймгийн Эрдэнэ суманд оршдог. Бага Хэнтийн нурууны өвөр хэсгийн иж бүрдлийг төлөөлөн Хан Хэнтийн дархан цаазат газартай хил залгаа орших уул, хад цохио, гол горхи хосолсон үсэсгэлэнт сайхан Горхи – Тэрэлжийн бүсийг байгалийн унаган төрхөөр нь хамгаалах, зохион байгуулалттай аялал жуулчлал хөгжүүлэх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах зорилгоор 293168 га талбайг 1993 онд УИХ-ын 83-р тогтоолд, 1994 онд Засгийн газрын 9-р тогтоолоор “Байгалийн цогцолбор газар” ангиллаар улсын тусгай хамгаалалтанд авсан.

Богд хан уул – Дархан цаазат газар: 1294 онд гаргасан Монгол Их Юань улсын хууль цаазын 398 дугаар бүлэгт “Богд хан уул, Отгонтэнгэр, Хан Хэнтий, Алтайн нүсэр даваа” зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг дархан цаазтай болгож байжээ. XII-XIII зууны үед Ван хан Тоорил дархлан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн домог байдаг. 1778 онд Монголын сэхээтнүүдийн нэг сайд Юндэндоржийн санаачилгаар Богд хан уулыг дархан цаазтай болгож 1957, 1974 онуудад дахин бататган дархалж, 1995 онд УИХ-ын 26 дугаар тогтоолоор дахин баталгаажуулсан байна. 1809 оноос Богдхан уулын 28 амыг цагдаатай

болгож, нутаг дэвсгэрт нь орох зөвшөөрлийг Богд хаан гардан олгодог журамтай байжээ. Богд хан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн гол нуруу, түүний салбар уулсаас тогтоно. Хамгийн өндөр оргил нь далайн төвшнөөс дээш 2268 метр өндөр Цэцээ гүн бөгөөд удаах нь 2256 метр Түшээ гүн оргил юм.

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг: Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулахын талбай нь “Хүйн гол” дүүргийн ОНТХГ-аас баруун урд зүгт 5.1 км, “Бурхантын ам” гэх дүүргийн ОНТХГ-аас баруун урд зүгт 6.8-7 км-ийн зайд байрлаж байна.

Зураг 15. Төсөл хэрэгжих талбай орчмын Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг



Төслийн талбайн Улсын болон Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

2.12. Нийгэм эдийн засаг

“Эко вест ойл” ХХК-ийн “Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах” зориулалттай төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт байрлаж байна.

Сонгинохайрхан дүүрэг нь Улаанбаатар хотын хүн ам шигүү суурьшсан хамгийн том дүүргийн нэг юм. Сонгинохайрхан дүүрэг нь Улаанбаатар хотын баруун хэсэгт Сонгинохайрхан уулын бэлд оршдог. Тус дүүрэг нь 1,200.6 км² газар нутагтай, 257550 гаруй хүн ам оршин суудаг. Засаг захиргааны 43 хороонд хуваагддаг. Тус дүүргийн хэмжээнд Ерөнхий боловсролын 24 сургууль, сургуулийн өмнөх боловсролын төрийн 81 цэцэрлэг үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Сонгинохайрхан дүүрэг 120.1 га нутаг дэвсгэртэй. Нийслэлийн баруун жигүүрт Баянгол дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдтай хил

залган оршдог. Монгол Улсын нийт хүн амын 11.6 хувь, Нийслэлийн нийт хүн амын 22.8 хувь, орон сууцны хорооллын 27.1 хувь, гэр хорооллын 72.9 хувь тус дүүрэгт байдаг.

Засаг захиргааны анхан шатны нэгж 43 хороотой. Орон сууцны 12 хороо, гэр хорооллын 22 хороо, холимог 9 хороо оршдог. Дүүргийн газар нутгийн 77 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20 хувийг ойн сав бүхий газар, 3 хувийг зам шугам сүлжээ, барилгажсан газар тус тус эзэлдэг.

Сонгинохайрхан дүүрэгт нийт үйл ажиллагаа явуулж байгаа 25865 аж ахуйн нэгж, байгууллагууд байдаг. Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээний дийлэнх хувийг хангадаг Улсын хэмжээний томоохон “Сүү” ХХК, “Талх чихэр” ХХК, “Алтан тариа” ХХК, “Мах импекс” ХХК, “Тесо” ХХК, “Милл хаус” ХХК, “Арвайн үндэс” ХХК зэрэг үйлдвэр, барилгын материалын “Хангай” зах, тоосгоны үйлдвэр болон хүнс худалдаа, үйлчилгээний 12500 гаруй аж ахуй нэгж, байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна.

Сонгинохайрхан дүүрэгт эрүүл мэндийн төв, салбар 2 амбулатори, Нэгдсэн эмнэлэг, салбар 1 амбулатори, 26 өрхийн эрүүл мэндийн төвүүд болон нийт 31 нэгжид 706 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд дүүргийн 342 мянга гаруй иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүргэж байна.

Хүн ам, өрхийн мэдээлэл: Сонгинохайрхан дүүрэг нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 96524 өрхийн 343439 хүн амтай бол 21-р хороо нь 2680 өрхийн 7625 хүн амтай байна. 2019 оноос 2022 онуудад 20-р хорооны хүн ам, өрхийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12. Сонгинохайрхан дүүргийн хүн амын тоо /хороогоор/

Баг, хороо	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	1499140	1539252	1596335	1640781	1677872
Сонгинохайрхан	335703	341540	342112	341390	343439
21-р хороо	4178	4812	4968	5463	7625

Хүснэгт 13. Сонгинохайрхан дүүргийн өрхийн тоо

Баг, хороо	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Улаанбаатар	414292	412527	431000	465059	475117
Сонгинохайрхан	94132	90231	91815	95895	96524
21-р хороо	1408	1657	1694	1849	2680

БҮЛЭГ-3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн байршилтай холбоотой нөлөөлөл

“Эко вест ойл” ХХК-ийн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21-р хорооны нутагт орших “Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах” төслийн талбайн орчимд хийсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хүрээн дэх нийгмийн судалгаагаар төслийн нөлөөллийг 2 бүсээр хуваан авч үзлээ. Үүнд:

- Төслийн талбайгаас 50 м зайд шууд нөлөөллийн бүс
- Төслийн талбайгаас 100 м зайд шууд бус нөлөөллийн бүсийг авч үзэв.

Хүснэгт 14. Төсөл хэрэгжих орчны нөлөөллийн бүс



Төслийн шууд бус нөлөөллийн 100 метрийн бүсэд барилга байгууламжууд өртөж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн эзэмшлийн талбайн ойр орчмын 100 м хүртлэх талбайд хяналт тавьж, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэн ажиллах шаардлагатай.

3.2. Агаарт үзүүлэх нөлөөлөл

Хуурайшилттай үед агаарт тоосны дэгдэлт нэмэгдэнэ. Энэ нь хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд сул хөрс шороо салхинд хийсч ойр орчны агаарыг тоосоор бохирдуулдаг бөгөөд орчны өнгө үзэмжийг алдагдуулдаг.

Нефтийн бүтээгдэхүүнээс агаарт дэгдэх нэгдлүүд: нүүрстөрөгчид, бензин, бензол, хүхэрт устөрөгч, хүхрийн диоксид, нүүрстөрөгчийн оксид, азотын оксид, бензпирен юм.

Агаарын чанарт нөлөөлөх гол үзүүлэлтүүдийг дор үзүүлэв:

Шатахуун түгээх, зөөвөрлөх, хадгалах үед үүсэх шатахууны ууршилт,

Шатахуун тээвэрлэх болон бусад тээвэрлэлтээс үүсэх тоос, Машин механизмаас гарах утаа.

3.3. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

ШТС нь шатахуун түгээх, хадгалах, тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагааны явцад сөрөг нөлөөлөл үүсэх нөхцөлтэй бөгөөд хөрсөнд нефтийн бүтээгдэхүүн алдагдвал хөрс бохирдох болон бусад үйл ажиллагаанаас тухайн газрын хөрс дагтаршиж, ургамал ургах чадвараа алдах,

Хөрсний бохирдолт- ШТС орчмын хөрс болон гадаргуугийн мөн газрын доорхи ус бохирдох явдал ихэвчлэн бүтээгдэхүүний шүүрэлт, гоожилтын алдагдал гаргаснаас болдог. Шатахуун шүүрч гоожиж алдагдах явдал нь савны битүүмжлэл алдагдах янз бүрийн байдлаар гэмтэл үүсэх мөн савыг халиулан шатахуун асгах, технологийн тоног төхөөрөмжүүдэд гэмтэл гарсан зэрэг шалтгаанаас болж гардаг. Шүүрэлт гоожилтын бас нэг онцлог бол тухайн объектын ашиглалтын нийт хугацааны туршид ямар нэг хэмжээгээр гарч байдаг явдал юм. Иймээс тухайн үед гарч байгаа шүүрэлт, гоожилтын алдагдлын хэмжээ хязгаарлагдмал байлаа ч гэсэн өөр газраар дахих алдагдал гарч болох учраас объектын газар талбай байнга ямар нэг хэмжээгээр бохирдох явдал гарч болно.

Шатах тослох материал, хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

3.4. Усан орчинд үзүүлэх нөлөөлөл

Гадаргын болон газрын доорхи усан дахь газрын тосны бүтээгдэхүүний задрал тархалт: Нефтийн бүтээгдэхүүн усанд алдагдвал усан дахь хүчилтөрөгчтэй нэгдэн давирхайлаг бодис үүсгэн, хар тугалга хүнд металлын байнгын эх үүсвэрийг бий болгодог. Бохирдлын цар хүрээ нь газрын доорхи гүний усны хөдөлгөөний дагуу тархаж, бохирдлын хүрээг тэлэх ба түүнийг бүрэн цэвэршүүлэх боломжгүй. Иймд газрын доорхи нефтийн бүтээгдэхүүн алдахгүй байх шаардлагатай. Гадаргын усанд нефтийн бүтээгдэхүүн алдагдсан тохиолдолд усны гадаргуу дээр хальс үүсгэн тогтох ба энэ нь удаан хугацаагаар байвал усан дахь хүчилтөрөгчтэй исэлдэж давирхайлаг бодис үүсгэн улмаар бензиний детоацийн тэсвэрийг дээшлүүлэх зорилгоор хольсон 4 этилт хар тугалга, хүнд хортой металлуудыг ангижруулдаг байна.

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон аюултай хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.

3.5. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Нефтийн бүтээгдэхүүн хөрсний үржил шим, ургамлын газар дээрх болон доорх фитомассыг багасгах хортой нөлөөлөлтэй.

Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрсөнд исэлдэн ангижрах ферментийн үйлчлэлээр явагдах урвалын хурд огцом удааширч, хөрсний хүчилтөрөгчийн грим мууддаг. Төрөл бүрийн ургамал нефтийн бүтээгдэхүүний бохирдлоос янз бүрийн хэмжээгээр хордохын хамт ургамлын бүрхүүлийн дулаан ялгаруулах чанарыг алдагдуулдаг.

3.6. Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь

Нефтийн бүтээгдэхүүн нь тээвэрлэлт, хадгалалт, хэрэглээний шинжээс хамаарч хүний эрүүл мэнд, байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлнэ. Энэ нөлөө нь хүний эд эс эрхтэнийг цоцроох үйлчилээс эхлээд гүнзгий хордлогод оруулна. Мөн байгаль орчныг хэт бохирдуулах, амьтан ургамлыг хөнөөх, хүний амьдрах орчныг доройтуулах сөрөг нөлөөтэй.

БҮЛЭГ-4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ

Ослоос сэргийлэх арга зам:

Гал түймрийн улмаас тухайн орчинд ихээхэн хохирол учруулахуйц аюул гарч болзошгүй тул аюул осол гаргахгүй ажиллахыг байнга анхаарах нь зүйтэй. Энэ бол уг объектод өгөх техникийн хамгийн чухал анхааруулга мөн.

Сав парк, түгээгүүрийн үйл ажиллагаанд байнга хяналт шалгалт хийж гэмтэл дутагдлуудыг тухайн цаг хугацаанд нь дүрэм журмын дагуу илрүүлэх, цахилгааны гэмтэл зэргийг илрүүлж засч ажиллах шаардлагатай.

Аюул ослоос байнга сэргийлэх, барилгын болон засварын ажлын үед /гануур хийх явцад/ гал түймрийн аюулаас болгоомжлох бүх арга хэмжээг авч ажиллахаас гадна аюул осол гархаас сэргийлсэн удирдлага зохион байгуулалт, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол явуулж байх шаардлагатай.

Гал түймрийн аюулаас сэргийлэх зөвлөмж:

Гал түймрийн гаралт, түүнээс үүсэх эрсдэл, эрсдэлээс учрах хохирлыг багасгах хамгийн чухал арга хэмжээ нь тухайн орон нутаг, байгууллагын аюулгүй байдлыг хангах асуудал юм. Аж ахуйн үйл ажиллагааны бүх л салбарт гал түймэр гарах магадлалын доод хэмжээ нь жилд нэг хүнд 10^{-6} тохиолдолоос хэтрэхгүй байх ёстой байдаг тэгэхээр аль ч орон нутаг, ямар ч аж ахуйн нэгж байгууллага нь галын аюулгүй байдлыг хангаж үйл ажиллагаагаа явуулах зайлшгүй шаардлага тулгарч байдаг.

- ШТС-д гарсан галыг өндөр, дунд болон нам өсөлтийн агаар механикийн хөөсөөр унтраахаар төлөвлөх, хөөсийг холболтыг хийж турших, хөөсний нөөцийг бий болгох;
- Цахилгаан хангамжийн гаднах дотор шугам сүлжээний холболтууд, хуваарилах тоноглолуудын техникийн /цахилгаан ил татсан утсуудыг гадны нөлөөнөөс хамгаалж суваглалт оруулж далдлах/ үзлэг үйлчилгээг тогтмол хийж газардуулга, аянга зайлуулагчийн бүрэн бүтэн байдалд жил бүр хэмжилт хийлгэн хяналт тавих, паспорт хөтлөх: /БН 43.101.03/
- Цахилгаан хангамжийн хуваарилах байгууламжуудад шугам сүлжээний техникийн үзлэг үйлчилгээг тогтмолжуулан, зам гарцуудын дагуух гэрэлтүүлгүүдийг сэргээн тодруулах, бэлтгэл тэжээл /нөөц/-ийн цахилгааны эх үүсгүүртэй байх: /ГХТХ-ийн 34.2.6, ЦБД-БД-43-101-03/
- ШТС-д тогтоосон хэмжээнээс илүүгээр ачааллыг нэмэгдүүлж газрын тосны бүтээгдэхүүн түүхий эд хурааж галын аюулын үед учруулах эмзэг байдал, эрсдэл /хохирол/-ийг нэмэгдүүлэхгүй байх /ГХТХ-ийн 34.2.2/
- Гал түймрийн онц аюултай эрсдэл бүхий объект учраас галын аюулгүй байдлын заавар, зөвлөгөө, мэргэжлийн туслалцаа авах зорилгоор галын мэргэжлийн /галын аюулгүй байдлын инженер/ боловсон хүчин авч ажиллуулах /орон тооны бус байж болно/
- Мөн гал унтраах насосны станцыг хариуцсан шаардлага гарсан үед ажиллуулж эвдрэл гэмтэл гарсан үед засаж сэлбэх яаралтай арга хэмжээ авч чадахуйц чадвар туршлагатай мэргэжлийн /галын насос, ус хангамжийн чиглэлийн мэргэжил бүхий/ албан тушаалтныг орон тоогоор томилох;
- Тээвэрлэлтийг техникийн үзлэгт хамрагдсан бүрэн ажиллагаатай машин техникээр зөвшөөрөгдсөн маршрутын дагуу тээвэрлэх, хяналт тавих
- Гал түймэртэй тэмцэх сайн дурын бүлэг, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн Аймгийн ОБХ-ийн гал унтраах мэргэжлийн албатай хамтарч гал унтраах тактик, тархалтын сургуулийн төлөвлөгөө, гал унтраах шуурхай картыг боловсруулан

батлуулж хамтарсан сургалтыг тогтсон хугацаанд хийж дадлагажуулах: ажилтан, албан хаагчдыг сургаж дадлагажуулах.

Ажилтан гүйцэтгэх албан тушаалтны хүрээнд:

- Гал унтраах хөөс, усны нөөцийг тогтмол хянаж өөр зориулалтаар ашиглахгүй байх;
- Гал унтраах, мэдээлэх системүүдэд хяналт тавиж ямар нэг өөрчлөлт, доголдол, дохио илэрсэн үед ахлах ажилтан болон инженерүүдэд мэдэгдэх;
- Гал унтраах анхан шатны болон гамшиг ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтанд хамрагдах;
- Гал түймэр гарсан үед галын байдалд үнэлэлт хийж дөнгөж үүсвэрлэж байгаа гал дээр гал унтраагуур, элс, эсгий зэргийг ашиглан унтраах арга хэмжээ авах ба гал түймэр тархан дэлгэрсэн эсвэл шатамхай шингэн, резервуар, тэсэрч болзошгүй химийн бодис, газрын тос тээвэрлэгч автомашин зэрэгт гал дамжсан байвал унтраах арга хэмжээ авахгүй бөгөөд аюулгүй зайг баримтлан гал унтраах ангийг угтан авах ажиллагаанд шилжих;

Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам:

ШТС орчмын зам талбайг бүтэн хатуу хучилттай болгох. Шатахуун нөөцлөх савнуудын битүүмжлэлийг тогтоосон цаг хугацаанд нь баталгаажуулах, савны их бага амьсгалын клапангаас гарч болох бензиний уурыг барьж авах тусгай тоног төхөөрөмжтэй байх, хатуу шингэн хог хаягдлыг битүү саванд хуримтлуулж, тогтоосон цэгт зохих журмын дагуу зайлуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам:

Нефтийн бүтээгдэхүүн алдагдсанаар хөрсөнд бохирдол үүсч болзошгүй. Бохирдлын эх үүсвэр нь шатахууны сав, шугам хоолой, бохирын цэг, хатуу хог хаягдал зэрэг болно. Асгарсан, ашигласан тосыг цуглуулан тусгай саванд савлах насос байрлуулах, шатахууныг цэнэглэх үед асгаж, алдахаас сэргийлэн хяналт тавьж асгарсан, алдсан тухай бүрд нь цэвэрлэн хор хөнөөлгүй болгох, сав тоног төхөөрөмжийн битүүмжлэл, буулгах үйл ажиллагааны горимыг чанд сахиж, шугам хоолойн холбоосны битүүмжлэлийг хангах, ШТС эзэмшил газрын орчныг тохижуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам:

Усан орчны бохирдлын эх үүсвэр нь нефтийн бүтээгдэхүүний алдагдал юм. Энэ нь нефтийн бүтээгдэхүүн хүлээн авах, түгээх болон аваар ослын үед асгарч гоожсоноос хөрс бохирдон, уг хөрсөөр дамжин гүний усыг бохирдуулах үндэслэлтэй. Нефтийн бүтээгдэхүүнийг усанд нэвчүүлэхгүйн улмаас алдагдсан эсэхийг хянах цооног буюу бүдүүн труба байрлуулах, аваарын сав насос байрлуулах, ахуйн шингэн хаягдлын цооног болон бие засах газрыг стандартын дагуу доторлон тохижуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх арга зам болно.

Ургамал нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах арга зам:

- Технологийн явцад сав, бусад тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- Нефтийн бүтээгдэхүүн ачих буулгах төхөөрөмжүүдээс гарах ууршилтын алдагдлыг бага байлгах технологийн арга хэмжээг иж бүрэн хэрэгжүүлэх
- Сав тоног төхөөрөмж, шугам хоолой, нээх-хаах арматуруудын техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах
- Шатах тослох материал болон хөрс бохирдуулах зүйлийг ил задгай хадгалахыг хориглоно

- Нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах, түгээх үйл ажиллагааны үед бүтээгдэхүүн асгарч орчныг бохирдуулсан нөхцөлд нэн яаралтай арга хэмжээ авах төлөвлөгөөтэй, хоргүйжүүлэх зааварчилгааг холбогдох хүмүүст өгч ажиллах
- Нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэлт явуулах замын хонхор хотгорыг дүүргэлт хийж тэгшилж нягтруулах, эвдэрч, элэгдсэн замыг тогтмол арчилж хэвийн байдалд байлгах
- Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, тусгайлсан хогийн цэгт түр хадгалан зохих журмын дагуу зайлуулах

Хог хаягдал зайлуулах

Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллах дараах зөвлөмжийг санал болгож байна.

Хог хаягдал зайлуулах асуудлыг “Хог хаягдлын тухай” Монгол улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ. Мөн хатуу хог хаягдлын цэгийг зонхилох салхины доод талд битүү тагтай зориулалтын саванд хадгалах ба байгууламжаас гадна байрлуулах бол 60 метрээс багагүй зайтай байрлуулах ёстой.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагатай.

2) Дараах шаардлагыг хангасан хогийн савтай болох шаардлагатай. Үүнд :

- Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн ;
- Галд тэсвэртэй материалаар хийгдсэн;
- Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх

Зураг 16. Санал болгож буй хогийн савны жишээ зураг



3) Сумын хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулж зайлуулах

4) Бусад :

- Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;
- Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;
- Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг

нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;

- Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;
- Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;
- Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;

БҮЛЭГ-5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллах, байгалийн баялгийг зохистой ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах нь бидний зорилго юм.

“Эко вест ойл” ХХК нь Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах төслийн хүрээнд 2025 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт **5134.0** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

Энд тусгагдаагүй зардлууд нь үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалын нэгдсэн дүн

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Нийт зардал (2025 он)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	650.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Мян.төг	1275.0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Мян.төг	2050.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян.төг	960.0
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян.төг	199.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян.төг	-
	Дүн		5134.0

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт 16. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	АГААР ОРЧИН							
1	Газрын тосны бүтээгдэхүүний ууршилтаас сэргийлэх	Албан байгууллагын автомашинд евро 5 стандартын түлш хэрэглэх	ГТБА-ын орчинд	мян.төг	ҮА-ны зардалаар		Тогтмол	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2015 Ажлын байрны орчин эрүүл ахуйн орчин
2		Асгарсан шатахууныг тухай бүрд нь арилгаж байх материалыг /элс, хаягдал зөөлөн даавуу гэх мэт/ нөөцлөн бэлдэх	Ашиглалтын туршид	мян.төг	350.0		Тогтмол	
3		Сав тоног төхөөрөмж, шугам хоолой, нээх-хаах арматуруудын техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах	Ашиглалтын туршид	мян.төг	ҮА-ны зардалаар		Тогтмол	
4		Газрын тосны бүтээгдэхүүн ачих-буулгах төхөөрөмжүүдээс гарах шатахуун, ууршилтын алдагдлыг бага байлгах технологийн арга хэмжээг иж бүрэн хэрэгжүүлэх	Ашиглалтын туршид	мян.төг	Дотоод төлөвлөлтөөр		Тогтмол	
ХӨРС, УРГАМЛАН НӨМРӨГ								
5		Хөрс бохирдсон тохиолдолд хөрсийг цэвэршүүлэн, шинж чанарыг сэргээх түргэн саармагжуулах материал нөөцлөх	ГТБА -ын талбайд	мян.төг	ҮА-ны зардалд		Тогтмол	Цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
6		Хөрсийг элэгдэл бохирдлоос хамгаалах, үүднээс орчны замын тэмдэг, тэмдэглэгээг байршуулах, засч, сэлбэх	ГТБА -ын талбайд	мян.төг	300.0		2025 онд	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7	Усан орчны бохирдол	ШТС-ын барилга байгууламжийн гадна, дотор талыг тогтмол цэвэрлэж байх	ГТБА -ын ашиглалтын үед	мян.төг	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	Усны тухай хууль Ус ашигласны төлбөрийн тухай хууль MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ	
8		Буулгах талбай болон цэнэглэх талбайгаас шатахуунаар бохирдсон хурын ус шороон хөрс рүү нэвчихээс сэргийлж, хурын улиралд нэмэлт хяналт хийж байх	ГТБА -ын ашиглалтын үед	мян.төг	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол		
Нийт					650.0			

5.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 17. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Орчны үзэмжийг сайжруулах, тоосжилтоос сэргийлэх, мод тарих	Гадна орчныг тохижуулах арчилж хамгаалах	ГТБА -ын хашаанд	-	-	ҮАЗ тусгах –д	ҮАЗ тусгах –д	2025 онд
2		ГТБА-ын сав парк болон барилга байгууламжид засвар үйлчилгээ, будаг, тохижилтын ажлыг тогтмол хийж гүйцэтгэх	ГТБА -ын хашаанд	-	-	150.0	150.0	2025 онд
3		“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд нэгдсэн зохион байгуулалтаар ногоон зурвас /мод тарих/ байгуулах ажилд оролцох	Дүүрэг орон нутгийн захиргаанаас санал болгосон талбайд	ш	50 ш хайлаас мод	22.5	1125.0	2025 онд
	Нийт						1275.0	

5.3. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа явуулж буй тус газар нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт байрлана. Тухайн талбайд түүх соёлын дурсгалт зүйл байхгүй бөгөөд төслийн хэрэгжилтийн үед ямар нэг зүйл илэрсэн үед мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, арга хэмжээ авна.

5.4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 18. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Оператор болон түгээгчдийн санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас ГТБА-ын орчинд нефть бүтээгдэхүүн алдагдах	Аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ-д тусгах	---*	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай хууль ШТС. Техникийн ерөнхий шаардлага /MNS 4628: 2013/ Даралтат савыг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм /2007 он/
2	Дизель түлш хадгалах нөөцлүүр савны эвдрэл, гэмтэл, цоорол	Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын хугацаанд байнга хяналт тавьж ажиллах.	ГТБА-д ашиглагддаг тоног төхөөрөмжүүд	850.0	2025 онд	
3	Ажиллагсадын эрүүл мэндэд нөлөөлөх	Ажиллагсдыг хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах	ГТБА-ын ажиллагсад	ҮАЗ-д тусгах	---*	
4		Галын аюулаас сэрэмжлүүлэх анхааруулга, санамж тэмдгийг байрлуулах, ХХАА-ны гарын авлага, мэдээллийн самбартай болох, засч сэлбэх	ГТБА-ын ажиллагсад	ҮАЗ-д тусгах	---*	
5	Галын аюул	Гал унтраагуурыг цэнэглэх	ГТБА-ын талбайд	1200.0	2025 онд	
6		Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт авах	ГТБА-ын талбайд	---*	2025 онд	
7		Бүх ажилчдад гал түймэр унтраах, аюулаас сэргийлэх заавар зөвлөгөөг тогтмол өгч ажиллах.	ГТБА-ын талбайд	---*	2025 онд	
8		Ус, элс шороо, хүрз, цэвэрлэгээний бодис, гал унтраах багаж хэрэгслээр бүрэн хангах	ГТБА-ын талбайд	ҮАЗ-д тусгах	2025 онд	
Нийт				2050.0		

5.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян. ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлыг эх үүсвэрээс нь эхлэн ангилан ялгалт хийж, дахин ашиглахгүй хаягдлыг холбогдох байгууллагатай гэрээ байгуулж зайлуулах	Төслийн талбайд	80.0	80.0x12сар=960.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р зүйл Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 5885:2016
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ГТБА зэрэг газарт хогийг ангилан ялгаж хаях хогийн савуудыг байрлуулах	Төслийн хүрээнд	-	ҮАЗардалд тусгах	2025 онд	
	Сав баглаа боодол нь гэмтсэн тос, тослох материалын хаягдал гарсан тохиолдолд тусгай саванд цуглуулж тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Хэрэглээний хэмжээгээр	ҮАЗардалд тусгах	Сар бүр	
	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх	Төслийн ажилчид	-	ҮАЗардалд тусгах	Сар бүр	
	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924 : 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” стандартын дагуу ашиглах,	Төслийн хүрээнд	-	ҮАЗардалд тусгах	Төслийн хугацаанд	
	Эзэмшил газрын гадна орчмын 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Төслийн хүрээнд	-	ҮАЗардалд тусгах	2025 оны 05 сараас	
Нийт				960.0		

5.6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаарх сургалтыг тогтмол зохион байгуулах	Улирал бүр	Дотоод төлөвлөлтөөр	--*--	Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл,
2	Гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх, тактикийн сургалтад хамрагдах	2025 онд	--*--		

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Нийт зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
3	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулж, дүгнүүлэх	Тухайн оны 11 -р сарын 01 - нээс өмнө	---*--	Байгаль орчны мэргэжлийн байгууллага	сөрөг нөлөөлөл, үр дагаварыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч болзошгүй алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж авах
Нийт					

5.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайд	Агаар-1 48°03'47.075"N 106°33'53.115"E	Жилд удаа 1	60.0 x 1 цэг = 60.0 /60.0 мян.төг – БОТЛаборатори/	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,
2. Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний ерөнхий, агрохимийн шинжилгээ	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Хөрс-1 48° 03' 45.98" 106° 33' 51.65"	Жилд удаа 1	Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж - 30.0 төг,	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон хог хаягдлаар хөрс бохирдох	Хөрс-1 48° 03' 45.98" 106° 33' 51.65"	Жилд удаа 1	33.0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 33.0 төг,	
	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ	Гэдэсний савханцар болон перпенгенсийн таньц, нянгаар бохирдох	Хөрс-1 48° 03' 45.98" 106° 33' 51.65"	Жилд удаа 1	30.0 /Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ 1 дээж 30.0 төг/	Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS 3297:1991
3. Усан орчин						

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
3.1	Усны шинжилгээ	Усны чанарт нөлөө үзүүлэх	Төслийн талбайд байрлах гүний худаг-т	Жилд 1 удаа	Усны шинжилгээ 1 дээж 46.0 төг	Ундны усны эрүүл ахуйг шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2017
Нийт					199.0	

5.8. Бомт-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 22. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	БОУАӨЯ-д	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг дүгнүүлэх	11 сарын 01-ний дотор	-	-

Зураг 17. Мониторинг хийх, дээж авах цэгийн байршил



Хүсэлтийн явцах дугаар: **329214287**

Татсан огноо: **2025-04-02 11:48**

Шилжүүлэгчийн дивайз дугаар	Хүлээн авагчийн дивайз	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
2815106634 MNR10015002815106634	100200955402	1,569,500.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭКО ВЕСТ ОЙЛ ХХК	Хүлээн авагчийн нэр СХДБ О НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга БОМТ НӨХӨН СЭРГЭЭЛТ 5956145 ЭКО БЭСТ ОЙЛ	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-04-02	

Гүйлгээг шилсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
О. ЭКО ВЕСТ		

Хүсэлтийн нэмэлт дугаар: 336889054

Татсан огноо: 2025-03-06 10:47

Шилжүүлэгчийн нэмэлт дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
2815106634 MNB10015002815106634	100200955402	997,500.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр ЭКО ВЕСТ ОЙЛ ХХК	Хүлээн авагчийн нэр СХД.БӨ НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга БОМТ НӨХӨН СЭРГЭЭЛТ 5956145 ЭКО БЭС Т ОЙЛ	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-03-06	

Гүйлгээг илгээсэн хэрэглэгч	Гүйлгээг хангасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
О. ЭКО ВЕСТ		



ШИЙТГЭЛИЙН ХУУДАС (маягт 2)

№ 0629524

оны сарын өдөр

хот, сум

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ ЗӨРЧИЛД ШИЙТГЭЛ ОНОГДУУЛАХ ТУХАЙ

..... /эрх бүхий албан тушаалтны харьяалах байгууллага, ажил, нэр, цол, зэрэг/ би Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ..

..... асуудлыг шалгаад ОЛСОН нь:

Холбогдогч /харьяалах улс, хуулийн этгээдийн нэр, хүний овог, нэр, регистр/паспортын дугаар, ажил, албан тушаал, хаяг/

..... -нь

болох нь зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдож,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэх боломжтой байна.

Иймд холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн

зүйлийн -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлд

заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-ийн үйлдсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн /зүйл, хэсэг, заалт/-д заасны дагуу /шийтгэлийн төрөл, хэмжээ/ шийтгэл оногдуулсугай.

2. Оногдуулсан шийтгэлийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, хохирол, нөхөн төлбөрийн төгрөгийг Төрийн сангийн тоот дансанд, зөрчил үйлдэж олсон мөнгөн орлогыг /улсын төсөвт/ Төрийн сангийн тоот дансанд тус тус шийтгэлийн хуудсыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бэлнээр, бэлэн бусаар сайн дураар төлж биелүүлэхийг даалгасугай.

3. Зөрчлийн тухай хуулийн 3.6 дугаар зүйлд зааснаар хүн, хуулийн этгээдийн /үйл ажиллагаа, эрх/ аль болохыг зурах/-ыг хугацаагаар /хязгаарлах, хүчингүй болгох/ аль болохыг зурах/ эрх хасах шийтгэл оногдуулсугай.

4. Торгуулийн шийтгэлийг хэсэгчлэн төлүүдэх үндэслэл тогтоогдсон тул оногдуулсан төгрөгийн торгуулийн шийтгэлийг хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор, хувийг хугацааны дотор хэсэгчлэн сайн дураараа биелүүлэхийг даалгасугай.

5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу хураан авсан:

А. Зөрчил үйлдэж олсон /хөрөнгө, орлого/, /аль нь болохыг доогуур зурах/

Б. Зөрчил үйлдэхэд ашигласан /зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга/, /аль нь болохыг доогуур зурах/

В. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой баримт болох /эд зүйл, баримт бичиг/

..... /аль нь болохыг доогуур зурах/

..... /нэр, төрөл, тоо, хэмжээ, шинж тэмдэг/-г Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.12 болон Засгийн газрын тогтоолоор баталсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын дагуу

..... шийдвэрлэсүгэй.

6. Холбогдогч /хүн, хуулийн этгээдийн нэр/-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар -ны өдрийн дотор үүргийг нөхөн биелүүлэхийг даалгах, эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төгрөгийн зардлыг гаргуулсугай.

7. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяалах шүүхэд хүсэлт гаргана.

8. Шийдвэрийг эс зөвшөөрвөл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдасугай.

ШИЙДВЭР ГАРГАСАН:

Эрх бүхий албан тушаалтан

ТАНИЛЦСАН:

Холбогдогч



(гарын үсэг)

(нэр)

оны сарын өдөр